

 SG INVESTMENT & SECURITIES

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2024-II

АГУУЛГА

| | | |
|-------|---|----|
| 1 | МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ | 4 |
| 1.1 | Дотоодын нийт бүтээгдэхүүн | 4 |
| 1.1.1 | Уул уурхайн салбар | 5 |
| 1.2 | Гадаад худалдаа | 6 |
| 1.2.1 | Экспортын гол бараанууд | 6 |
| 1.2.2 | Импортын гол бараанууд | 7 |
| 1.2.3 | Гадаад худалдааны гол түнш улсууд | 7 |
| 1.3 | Бодлогын хүү | 8 |
| 1.4 | Инфляц | 8 |
| 1.5 | Улсын төсөв | 9 |
| 1.5.1 | Төсвийн зарлага | 9 |
| 1.6 | Төсвийн орлого | 10 |
| 1.7 | Засгийн газрын нийт өр | 10 |
| 1.8 | Гадаад валютын албан нөөц | 11 |
| 1.9 | Мөнгөний нийлүүлэлт | 11 |
| 1.10 | Төлбөрийн тэнцэл | 12 |
| 2 | ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ | 13 |
| 2.1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл | 13 |
| 2.2 | Инфляцын төсөөлөл | 13 |
| 2.3 | 2024 оны улсын төсөв | 14 |
| 3 | ДҮГНЭЛТ | 15 |

ГРАФИКЫН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| График 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр /их наяд төгрөг/ | 4 |
| График 2. Нүүрсний экспорт /сая.тн/ | 5 |
| График 3. Уул уурхайн зарим бүтээгдэхүүний олборлолт /сая тн/ | 5 |
| График 4. Гадаад худалдаа /сая ам.доллар/ | 6 |
| График 5. 2023 оны экспортын орлого /сая ам.доллар/ | 6 |
| График 6. 2023 оны импортын орлого /тэрбум ам.доллар/ | 7 |
| График 7. Бодлогын хүү /хувиар/ | 8 |
| График 8. Инфляцын түвшин/хувиар/ | 8 |
| График 9. Улсын төсөв /их наяд төг/ | 9 |
| График 10. Засгийн газрын нийт өр /тэрбум төг/ | 10 |
| График 13. ГВАН /сая ам.доллар/ | 11 |
| График 14. Мөнгөний нийлүүлэлт /их наяд төг/ | 11 |
| График 17. ДНБ, төсөөлөл /өсөлтийн хувиар/ | 13 |
| График 18. Төсвийн төсөөлөл /их наяд төг/ | 14 |


ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Хүснэгт 1 Салбаруудын хувь нэмэр /ДНБ оны үнээр, тэрбум төг/ | 4 |
| Хүснэгт 2. Экспорт, импортын түлш улсууд | 7 |
| Хүснэгт 3 Нэгдсэн төсвийн нийт зарлага, эдийн засгийн салбараар /тэрбум төг/ | 9 |
| Хүснэгт 4. Улсын төсвийн орлогын задаргаа /тэрбум төг/ | 10 |
| Хүснэгт 5. Уул уурхайн салбарын орлого | 10 |
| Хүснэгт 6. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/ | 12 |

1 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

График 1. Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хүснэгт 1 Салбаруудын хувь нэмэр /ДНБ оны үнээр, тэрбум төг/


| Бүрэлдэхүүн | 2023-IV | Өсөлтийн хувь |
|--|---------|---------------|
| ДНБ | 37.42 | 5.6% |
| Хөдөө аж ахуй | 3.40 | -26.7% |
| Уул уурхай, олборлолт | 11.08 | 15.4% |
| Боловсруулах үйлдвэрлэл | 1.82 | 6.3% |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 0.73 | 5.3% |
| Барилга | 0.55 | 19.5% |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ | 3.03 | 6.8% |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 2.22 | 24.7% |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал уул уурхай 15.4 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 24.7 хувиар, бөөний болон барилгын салбар 19.5 хувиар өссөн нь эдийн засаг өсөх шалтгаан болсон. ХАА салбарын хувьд өвөлжилт хаваржилт хүндэрсний улмаас тус салбар -26.7 хувиар агшив. Малын хорогдол энэ оны эхний улиралд 6.3 сая толгойнд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгойгоор өндөр үзүүлэлт болсон нь ХАА салбарын бууралтад гол нөлөө үзүүлжээ.

1.1.1 Уул уурхайн салбар


График 2. Нүүрсний экспорт /сая.тн/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Монгол Улсын эдийн засгийн чухал хүчин зүйл болох нүүрсний экспорт нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 40.6 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 37.6 хувиар нэмэгджээ. БНХАУ-ын хойд мужуудад хэрэгжиж буй дэд бүтцийн төслийн нөлөөгөөр нүүрсний экспорт нэмэгдэх гол хүчин зүйл болов. Тус 40.6 тонн нүүрсний 14.55 сая тонн нүүрс нь Монголын Хөрөнгийн Биржээр ил тод нээлттэй арилжаалагджээ. 2024 онд Монгол Улс нийт 60 сая тонн нүүр экспортлохоор төлөвлөсөн бол оны эхний 6 сарын байдлаар төлөвлөгөөний 66 хувьд хэдийнээ хүрээд байна.

График 3. Уул уурхайн зарим бүтээгдэхүүний олборлолт /сая тн/




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Уул уурхайн салбарын хувьд нүүрс олборлолтоос гадна зэс, жоншны хүдэр, олборлолт өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал зэсийн баяжмалын үйлдвэрлэл 790 мянган тоннд хүрч 2 хувь, жоншны хүдэр 580 мянган тоннд хүрч 32 хувиар өссөн бол боловсруулаагүй нефт 12 хувиар бууралт үзүүлэв.

1.2 Гадаад худалдаа

График 4. Гадаад худалдаа /сая ам.доллар/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Монгол Улс тайлант хугацаанд 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.3 тэрбум ам.долларт хүржээ. Үүнээс импорт 5.4 тэрбум ам.доллар, экспорт 7.9 тэрбум ам.долларт хүрч, нийт гадаад худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан үзүүлэлттэй байна. Нийт экспорт өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар, импорт 25.9 хувиар, тэнцэл 23.5 хувиар тус тус өсжээ.

1.2.1 Экспортын гол бараанууд

График 5. 2023 оны экспортын орлого /сая ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар

Уул уурхайн бүтээгдэхүүн 2024 оны эхний хагас жилийн экспортын 93 хувийг бүрдүүлжээ. Түүнчлэн нүүрсний экспорт дан ганцаараа 60 хувийг бүрдүүлсэн үзүүлэлттэй гарсан. Уул уурхайн бус бүтээгдэхүүний хувьд ноолуур 148 ам.долларын орлого хийжээ.

1.2.2 Импортын гол бараанууд

График 6. 2023 оны импортын орлого /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импортын орлого 9.2 тэрбум ам.долларт хүрсэн. Үүний 12 хувь ба 1.11 тэрбум ам.долларыг дизель түнш, 7.32 хувийг буюу 0.68 тэрбум ам.долларыг хөнгөн тэрэг, эзэлж байгаа бол автобензин 5.65 хувь бөгөөд 0.20 тэрбум ам.долларыг эзэлсэн үр дүнтэй гарлаа. Монгол Улсын 2023 оны импортын бараа бүтээгдэхүүний БНХАУ 40.6 хувь, ОХУ 25.7 хувь, Япон 7.8 хувь, БНСУ 4.5 хувь, АНУ 3.1 хувь, ХБНГУ 2.3 хувийг тус тус эзэлж, нийт импортын 84.0 хувийг бүрдүүлж байна.


1.2.3 Гадаад худалдааны гол түнш улсууд

Хүснэгт 2. Экспорт, импортын түлш улсууд

| Экспортын гол түнш улсууд | Импортын гол түнш улсууд |
|--------------------------------------|--------------------------------------|
| БНХАУ – 92.7% (7.3 тэрбум ам.доллар) | БНХАУ – 40.8% (2.2 тэрбум ам.доллар) |
| Швейцар – 4.3% (340.9 сая ам.доллар) | ОХУ – 25.3% (1.4 тэрбум ам.доллар) |
| ОХУ – 0.7% (55 сая ам.доллар) | Япон – 9.6% (516 сая ам.доллар) |
| Нигер – 0.4% (34 сая ам.доллар) | БНСУ – 4.1% (222 сая ам.доллар) |
| Итали – 0.3% (24.6 сая ам.доллар) | АНУ – 3.6% (191.4 сая ам.доллар) |
| Бусад – 1.5% (119.9 сая ам.доллар) | ХБНГУ – 2.1% (112 сая ам.доллар) |
| | Бусад – 14.5% (779.7 сая ам.доллар) |

1.3 Бодлогын хүү


График 7. Бодлогын хүү /хувиар/



2022 оны сүүлээс хойш 15 сарын хугацаанд 13 хувь байсан бодлогын хүү тайлант хугацаанд хоёр удаа өөрчлөгдөж 11 хувь болсон. Инфляцын бууралт мөн экспортын өсөлт нь валютын орох урсгал, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөлж байгаа нь бодлогын хүүг бууруулах гол хөшүүрэг болжээ.

1.4 Инфляц

График 8. Инфляцын түвшин/хувиар/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Инфляцын түвшин өмнөх оны мөн үед 10.6 хувьтай байсан бол 2024 оны 6 дугаар сарын байдлаар 5.1 хувь болж 5.5 нэгж хувиар буурч Монголбанкны 6+2 хувийн зорилтод түвшинд хүрсэн байна. Үүнд гадаад инфляц буурч, төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарснаар импортын хүнс, бараа, дотоодын бараа бүтээгдэхүүн үйлчилгээний инфляц бага гарсан зэрэг нь гол нөлөө үзүүлжээ.

1.5 Улсын төсөв

График 9. Улсын төсөв /их наяд төг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.5.1 Төсвийн зарлага

Хүснэгт 3 Нэгдсэн төсвийн нийт зарлага, эдийн засгийн салбараар /тэрбум төг/

| Үзүүлэлт | 2023.06 | 2024.06 | зөрүү |
|-----------------------------------|----------|-----------|----------|
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дун | 9,033.83 | 12,911.30 | 3,877.46 |
| Урсгал зардал | 7,556.65 | 10,376.24 | 2,819.59 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 2,044.63 | 4,244.83 | 2,200.21 |
| Хүү | 513.80 | 595.11 | 81.30 |
| Татаас ба шилжүүлэг | 4,998.22 | 5,536.30 | 538.08 |
| Хөрөнгийн зардал | 1,443.88 | 2,296.00 | 852.12 |
| ЦЭВЭР ЗЭЭЛ | 33.30 | 239.06 | 205.75 |

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээ 12.9 их наяд төгрөгт хүрч 2024 оны батлагдсан дүнгийн 47.1 хувьд хүрсэн байна. Нийт зарлагын 4.2 их наядыг буюу 32.9 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулжээ.

1.6 Төсвийн орлого

Хүснэгт 4. Улсын төсвийн орлогын задаргаа /тэрбум төг/

| Үзүүлэлт | 2023.06 | 2024.06 | зөрүү |
|--------------------------------------|-----------------|-----------------|----------------|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 11,059.3 | 14,947.2 | 3,887.8 |
| Тогтворжуулалтын сан | 477.9 | 220.7 | -257.3 |
| Тэнцвэржүүлсэн орлого | 10,581.3 | 14,198.8 | 3,617.5 |
| Татварын орлого | 9,841 | 13,291.0 | 3,449.8 |
| Татварын бус орлого | 740.1 | 907.8 | 167.7 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээ 14.95 их наяд төгрөгт хүрч 2024 оны батлагдсан улсын төсвийн зорилтын 58 хувьд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 35.2 хувиар өсжээ. Үүнд уул уурхайн экспорт 40.6 сая тоннд хүрч, уул уурхайн тээвэр, хадгалалт, үйлчилгээний салбарын орлого нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлэв. Уул уурхайн салбараас тайлант жилийн хугацаанд улсын төсөвт нийт 6.37 их наяд төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд 2023 оны эхний хагас жилтэй харьцуулахад 73 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Уул уурхайн салбарын орлого

| Үзүүлэлт | 2023.06 | 2024.06 | зөрүү |
|------------------------------------|----------------|----------------|----------------|
| Уул уурхайн салбарын орлого | 3,684.2 | 6,371.3 | 2,687.1 |
| Нүүрс | 2,110.6 | 4,519.1 | 2,408.5 |
| Төмрийн хүдэр | 46.8 | 87.9 | 41.1 |
| Алт | 114.3 | 179.8 | 65.5 |
| Зэсийн баяжмал | 1,221.1 | 1,367.6 | 146.5 |

Эх сурвалж: Сангийн яам

1.7 Засгийн газрын нийт өр

График 10. Засгийн газрын нийт өр /тэрбум төг/

| | 2022-II | 2022-IV | 2023-II | 2023-IV | 2024-II |
|--------------------------|----------|----------|----------|----------|----------|
| Засгийн газрын нийт өр | 28,523.3 | 31,945.1 | 31,110.6 | 30,765.0 | 30,247.1 |
| Засгийн газрын дотоод өр | 531.8 | 1,035.5 | 651.6 | 234.1 | 141.6 |
| Үнэт цаас | 531.8 | 1,035.5 | 651.6 | 234.1 | 141.6 |
| Засгийн газрын гадаад өр | 26,559. | 29,619.1 | 29,372.1 | 30,319.5 | 29,346.5 |
| Үнэт цаас | 8,994.9 | 9,359.8 | 9,070.6 | 9,371.5 | 8,716.3 |
| Зээл | 17,564.1 | 20,259.3 | 20,301.4 | 20,947.8 | 20,630.2 |


Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын 600 сая ам.долларын төлбөрийг бүрэн төлсөн бөгөөд үүнд 2023 онд хийсэн хуралдай бондын төлбөрийг санхүүжүүлэх хүрээнд “Сенчири-II” “Сенчири-III” өрийн зохицуулалтын хүрээнд 547.1 сая ам.долларыг, үлдэгдэл 52.9 сая

ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулжээ. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 20,630.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Тайлант хугацаанд нийт ашиглалтын хэмжээ 1,154.5 тэрбум төгрөгтэй, үндсэн төлбөрийн хэмжээ 604.4 тэрбум төгрөгтэй, хүүгийн төлбөр 284.6 тэрбум төгрөгтэй тус тус тэнцэж байна.

1.8 Гадаад валютын албан нөөц

График 11. ГВАН /сая ам.доллар/




Эх сурвалж: Монголбанк

2022 оны эхний хагас жилийн байдлаар гадаад валютын нөөц 2.7 тэрбум ам.долларт хүрч Монгол Улс гадаад валютын хүндхэн байдалд орж байсан бол энэ оны эхний хагас жилд 4.8 тэрбум ам.доллар болж тухайн үеэс 1.8 дахин нэмэгджээ. Гэвч энэхүү нөөц нь 2024 оны эхээр өсөж, 3-р сард 5.25 тэрбум ам.долларт хүрч дээд хэмжээгээ тогтоосон ч, түүнээс хойш зарим бууралт ажиглагджээ. Уул уурхайн олборлолт нэмэгдэж үүнийгээ даган экспорт нэмэгдсэн ч импортын барааны өсөлт нь гадаад валютын албан нөөцийг бууруулах шалтгаан болгожээ

1.9 Мөнгөний нийлүүлэлт

График 12. Мөнгөний нийлүүлэлт /их наяд төг/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын 2024 оны эхний хагас жилийн мөнгөний нийлүүлэлт огцом өсөлттэй байсан бөгөөд 6 дугаар сарын байдлаар 41.42 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх саруудаас илүү өндөр дүн бөгөөд тавдугаар сард 39.07 их наяд төгрөг байсан юм. 2024 оны эхний хагас жилийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь банкны хадгаламж болон бусад мөнгөний хэлбэрээр эдийн засагт нийлүүлэгдсэн дүнг илэрхийлдэг. Өсөлтөд инфляцын түвшин, зах зээлийн эрэлт зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна.

1.10 Төлбөрийн тэнцэл

Хүснэгт 6. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/

| Үзүүлэлт | Он | | | Өөрчлөлт Дүн |
|-------------------------|----------|---------|---------|-----------------|
| | 2022.06 | 2023.06 | 2024.06 | |
| Урсгал данс | -1,360.8 | 221.2 | -309.2 | -530.3 |
| Хөрөнгийн данс | 54.6 | 59.9 | 78.3 | 18.4 |
| Санхүүгийн данс | -925.8 | -58.3 | -720.8 | -662.4 |
| Алдаа болон орхигдуулаг | -677.5 | 134.4 | -547.1 | -681.5 |
| Нөөц хөрөнгө | -1,058.0 | 473.7 | -57.3 | -531.0 |


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын төлбөрийн тэнцлийн урсгал данс 309.2 сая ам.долларын алдагдалтай, төлбөрийн тэнцэл 57.3 сая ам.долларын алдагдалтай гарсан бол өмнөх оны мөн үед урсгал данс 221.2 сая ам долларын ашигтай гарсан билээ. Тус бууралтад хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал, үйлчилгээний салбарын төлбөрийн тэнцэл сөрөг үр дүн үзүүлж, 2024 оны 4-р сарын байдлаар -184.99 сая ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь 2024 оны 1-р сард -349 сая ам.доллар хүртэл буурсан үзүүлэлтээс сайжирсан ч, сөрөг үзүүлэлт хэвээр үлдсэн байна. Голлох хүчин зүйлсийн нэг нь экспорт, импортын зөрүүгээс үүссэн бараа үйлчилгээний төлбөрийн тэнцлийн алдагдал юм. Мөн дэлхийн зах зээл дээрх таваарын үнийн хэлбэлзэл, тээвэрлэлтийн зардал, дотоодын эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нь Монгол Улсын төлбөрийн тэнцэлд нөлөөлсөн. Энэ хугацаанд Монгол Улсын экспортын өсөлт тогтвортой байхад, импортын хэмжээ өсөж, үйлчилгээний салбарын алдагдал үргэлжлэн буурснаар төлбөрийн тэнцэл сөрөг чиглэлд явсан байна.

2 ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл

График 13. ДНБ, төсөөлөл /өсөлтийн хувиар/



2024 оны эхний хагас жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт 4-6 хувь орчим байх төлөвтэй байна. Энэхүү өсөлтийг голчлон уул уурхайн салбар, ялангуяа Оюу толгой төслийн олборлолтын нэмэгдэл дэмжиж байна. Гэвч хөдөө аж ахуйн салбарт "зуд" хэмээх байгалийн гамшгийн улмаас агшилт гарч байгаа нь эдийн засгийн бусад салбаруудад сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн 2025 он гэхэд ДНБ-ний өсөлт 6.0% болж өсөх төлөвтэй байна. Энэ өсөлтийг хөдөө аж ахуйн салбарын сэргэлт, уул уурхай болон үйлчилгээний салбарын өргөжилт дэмжих юм. Гэсэн хэдий ч инфляцын түвшин 2024 онд 7.0%, 2025 онд 6.8% байхаар хүлээгдэж байгаа бөгөөд гадаад худалдааны тэнцэл дахин алдагдалтай гарах магадлалтай байна. Эдийн засгийн өсөлтөд тулгарах эрсдэлүүдийн нэг нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хөдөө аж ахуйн хүндрэлийн улмаас гарч болзошгүй хямрал байж болох юм. Үүний зэрэгцээ, нүүрс экспортлогч БНХАУ-ын эрэлт буурвал уул уурхайн бүтээгдэхүүний үнэ мөн хямдрах эрсдэлтэй байна.

2.2 Инфляцын төсөөлөл



2025 онд Монгол Улсын инфляцын түвшин ойролцоогоор 5-6 хувь орчимд тогтворжино гэж төсөөлж байна. Монголбанкнаас дэвшүүлсэн зорилгоор инфляцыг 2025-2026 онд +/-2 хувийн интервалтайгаар 6 хувь орчимд барьж, улмаар 2027 оноос эхлэн 5 хувьд хүргэхээр төлөвлөжээ. Энэ нь мөнгөний бодлого, валютын ханшийн уян хатан байдал зэрэг хүчин зүйлсээс хамаарна. Түүнчлэн, гадаад эдийн засгийн нөхцөл байдал, импортын бүтээгдэхүүний үнэ, төсвийн тэлэлт зэрэг нь инфляцад нөлөөлөх магадлалтай байна. Түүхий эдийн үнийн өсөлт, хүнсний хангамж сайжрах төлөвтэй байгаа ч зарим хүчин зүйлсийн улмаас Монголд инфляц харьцангуй өндөр хэвээр хадгалагдаж магадгүй байна. Тухайлбал, валютын ханшийн сулралт болон импортын барааны үнэ зэрэг хүчин зүйлс үүнд нөлөөлөх боломжтой юм.

2.3 2024 оны улсын төсөв

График 14. Төсвийн төсөөлөл /их наяд төг/

| Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | 2024 I-VI | 2024 IV-XII* |
|---------------------------------------|-----------|--------------|
| Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого | 14.2 | 28.9 |
| Нэгдсэн төсвийн нийт зарлага | 12.9 | 30.5 |
| Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл | 1.3 | -1.6 |
| ДНБ-д эзлэх хувь | 3.4% | -2.0% |
| ЗГ-н өрийн нийт хэмжээ | 30.2 | 35.2 |
| ДНБ-д эзлэх хувь | 38.3% | 44.4% |

Эх сурвалж: Сангийн яам

3 ДҮГНЭЛТ

Монгол Улсын эдийн засаг 2024 оны эхний хагас жилд 5.6 хувиар өссөн бөгөөд эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал уул уурхай 15.4 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 24.7 хувиар, бөөний болон барилгын салбар 19.5 хувиар өссөн нь эдийн засаг өсөх шалтгаан болсон. Нүүрсний экспорт 40 сая тоннд хүрч 2024 оны төлөвлөгөөний 66 хувьд хэдийнээ хүрэв. Нүүрсний экспортын нөлөөгөөр гадаад худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.доллараар эерэг гарсан ч импортын өсөлт экспортын өсөлтөөс өндөр байна. Импортын барааны өсөлтөөс үүдэлтэйгээр төлбөрийн тэнцэл болон гадаад валютын албан нөөцөд сөрөг үр дүн авчирсан үзүүлэлттэй байна. Тухайлбал төлбөрийн тэнцэл 57.3 сая ам.долларын алдагдалтай гарсан бол гадаад валютын албан нөөц 2024 оны эхээр өсч, 3-р сард 5.25 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд оргилдоо хүрсэн ч 6 дугаар сард 4.8 тэрбум ам.долларт хүрч буурчээ. Инфляцын хувьд аажмаар буурч байгаа ч оны төгсгөлд нэмэгдэж 6.5 хувьтай гарах төлөвтэй байна.